

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС  
ХОНГКОНГИЙН ЦАГ УУРЫН ТӨВД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “НИСЭХИЙН ЦАГ  
УУРЫН ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ” СЭДЭВТ  
СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

1. Сургалт семинарын зорилго:

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн цаг уурын байгууллагад зохион байгуулагдсан “Нисэхийн цаг уурын шинжлэх ухаан болон үйлчилгээний хөгжил” сэдэвт сургалт семинарт хамрагдаж, нислэг хөдөлгөөний үйлчилгээ, агаарын тээврийн байгууллагуудад үзүүлж буй нисэхийн цаг уурын мэдээний чанарыг сайжруулах, шинжлэх ухаан технологийн ололтыг цаг уурын үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх арга замыг судалж сурах зорилготой.

Сургалт семинарт хамрагдсан ажилтан:

Нислэгийн цаг уурын төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн  
ТЗСАМэргэжилтэн Ж.Энхболд

2. Сургалт семинар зохион байгуулагдсан газар:

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн цаг уурын байгууллагад зохион байгуулагдсан.

3. Хугацаа:

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд.

4. Сургалт семинарын талаар:

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн цаг уурын байгууллагад зохион байгуулагдсан “Нисэхийн цаг уурын шинжлэх ухаан болон үйлчилгээний хөгжил” сэдэвт сургалт семинарт амжилттай хамрагдлаа.

Сургалт семинарын үеэр БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгод “Бүс ба Зам” хүрээнд хамрагдаж буй улсуудад зориулсан Дэлхийн цаг уурын байгууллагын Сургалтын төвийг шинээр нээсэн онцгой үйл явдал боллоо. Энэхүү сургалт семинарыг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн цаг уурын байгууллагын сургалт, хөгжил эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, сургагч багш нар удирдан явуулсан. Сургалт семинарт ашиглагдсан бүх материал, мэдээ мэдээллийг электрон хэлбэрээр авчирсан.

Энэхүү сургалт семинарт 26 улс болон олон улсын 2 байгууллагаас нийт 40 гаруй төлөөлөгч оролцсон. Үүнд: Пакистан улсаас-1, Папуа Шинэ Гвиней улсаас-1, Соломон Арлууд-1, Аргентин улсаас-1, Бүгд Найрамдах Бенин улсаас-1, Бүгд

Найрамдах Кипр улсаас-1, Швейцар улсаас-1, Бруней Даруссалам улсаас-2, Тайланд улсаас-3, Науру улсаас-1, Монгол улсаас -2, Өмнөд Солонгос улсаас-2, Непал улсаас-1, Малайз улсаас -2, Лаос улсаас-3, Мальдив улсаас-1, Вьетнам улсаас-3, Сингапур улсаас -1, Индонез улсаас-2, Шри-ланка улсаас-2, Вануату улсаас-1, Фижи улсаас-2, Энэтхэг улсаас -1, Күүкийн арлууд-1, Бангладеш улсаас-3, Камбож улсаас-3, Йордан улсаас-1, Эсватани улсаас-1, Өмнөд Африкаас-1, БНХАУ-аас -3 оролцогч тус тус оролцсон.

Сургалт семинарын хугацаанд дараах сэдвүүдийг судаллаа. Үүнд:

- Нисэхийн цаг уурын үйлчилгээ үйл ажиллагааны хөгжлийн талаар;
- Нисэхийн цаг уурын үйлчилгээнд AI хиймэл оюун ухааныг ашиглах талаар;
- Нисэхийн цаг уурын мэдээний чанарыг дээшлүүлэх, үйлчилгээг сайжруулж буй бусад орны туршлагауд, нисэхийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж буй холбооны мэдээлэл төлөвлөлтийн систем(SWIM)-ийн хүрээн дэх IWXXM-ийн хэрэгжилтийн үе шат;
- ИКАО-гоос Чикагогийн конвенцын Хавсралт-3-д нэмэлт өөрчлөлт оруулах төлөвлөгөө.

Нислэгийн цаг уурын урьдчилсан мэдээнд хиймэл оюун ухааныг ашиглаж AI буй байдал, эрдэм шинжилгээ судалгааны ажил, олон улсын агаарын навигацид үзүүлж буй цаг уурын үйлчилгээг хөгжүүлж сайжруулах талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ийн хэтийн төлөв, Системийн өргөн мэдээллийн менежмент (SWIM)-ын цаг уурын мэдээллийн үйлчилгээний хөгжил, ДЦУБ-ын нисэхийн цаг уурын хөгжил судалгааны ажлын төслийн 2-р үе шат (AvRDP2)-ийн шинэчлэлтүүд, цаг уурын мэдээг урьдчилан мэдээлэх ур чадвар, нисэх баг болон бусад хэрэглэгчдийг зөвлөмж зөвлөгөөгөөр хэрхэн хангаж байгаа талаар хэлэлцэж сургалт семинарт оролцогч төлөөлөгчидтэй харилцан туршлага солилцож, мэдээлэл авлаа.

Нисэхийн цаг уурын үйлчилгээнд тавигдаж буй Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-ын стандарт шаардлагын хэрэгжилт болон баримт бичгүүдийн өөрчлөлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ бусад улсуудын нисэхийн цаг уурын үйлчилгээний цаашдын чиг хандлага, тулгарч буй асуудлуудаар гаргаж буй тодорхой шийдвэрүүдтэй танилцсан.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас нисэхийн цаг уурын чиглэлээр дэлхийн болон бүсийн хэмжээнд баримталж буй бодлого, төлөвлөгөө нэн тэргүүний зорилго, зорилтуудыг эргэн нягталж, Чикагогийн конвенцын Хавсралт-3-д оруулах төлөвлөгөөг ярилцсан. ИКАО-гоос 2024 онд 81 дүгээр, 2025 онд 82 дугаар, 2027 онд 83 дугаар, 2030 онд 84 дүгээр нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байна. Улс орнуудын олон улсын цаг уурын мэдээлэл солилцооны IWXXM форматын хэрэгжүүлэлт, шинэчлэлт, онцгой үзэгдлийн зураг зэргийг танилцуулсан. Оролцогч улс орнуудын нисэхийн цаг уурын байгууллага нь ОУИНБ-ын стандарт шаардлагын хүрээнд IWXXM форматыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ ажлын хэрэгжилтийн талаар тодорхой мэдээлэл өгсөн.

Сургалт семинарт оролцогчид өөрийн орны нисэхийн цаг уурын байгууллагын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлж буй техник

технологийн ололт амжилт болон нислэг хөдөлгөөний хамтын ажиллагааны талаар танилцуулж тэдгээрийн давуу болон сул талууд цаашид нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулахад хийгдэх шаардлагатай ажлуудын талаар танилцуулга илтгэл тавьж хэлэлцүүлсэн .

Сургалт семинарт оролцогч улс орнуудаас Солонгос улс нь манан прогнолох судалгааны аргачлал буюу загварчлал болон салхины шилжлэг, сэгсрэлтийг урьдчилсан мэдээлэх судалгааны ажлуудын талаар танилцуулга хийсэн.

Мөн SIGMET мэдээний шинэчлэлт, хөрш зэргэлдээх улс орнуудын SIGMET мэдээний хамтын ажиллагаа, WAFS бүтээгдэхүүний шинэчлэлтийн тухай болон агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж буй цаг уурын мэдээлэл солилцоо, хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чиглэлээр хийгдсэн ололт амжилтын талаар яригдлаа. БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн нисэхийн цаг уурын байгууллагад ашиглагдаж буй багаж тоног төхөөрөмж болон программ хангамж, платформуудтай танилцсан болно.

Дэлхийн цаг уурын байгууллагаас нисэхийн цаг уурын үйлчилгээний чиглэлээр баримталж буй бодлого, зорилго хэтийн төлөвлөгөө, нисэхийн цаг уурын ажилтнуудын сургалт, ур чадварын шаардлагууд хүний хүчин зүйлс ба нисэхийн цаг уурын инженер, техникийн ажилтнуудын сургалттай холбогдолтой асуудлуудыг Дэлхийн цаг уурын байгууллагын нисэхийн цаг уурын үйлчилгээ хариуцсан ахлах Mr. Greg Brock танилцуулсан.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр байгалийн гамшгийн тоо давтагдал ихэсч учруулж буй хор хөнөөл нь жилээс жилд нэмэгдсээр байгаа ба нислэгт хэрхэн нөлөөлж байгаа талаар танилцуулга хийж цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо өсөж байгаа нь нислэгт ялангуяа цаг агаарын мэдээний чанар таарцад ихээхэн нөлөө үзүүлж байгааг энэ үеэр онцолж байсан.

## 5. Гарсан үр дүн:

Сургалт семинар маш их мэдээллийг агуулсан, чанартай болсон бөгөөд бусад улс орнуудын нисэхийн цаг уурын үйл ажиллагаанд ашиглаж буй тоног төхөөрөмж, үйлчилгээг бусад улс орнуудаас туршлага судлан цаашдын үйл ажиллагааг сайжруулахад ашиглаж болохуйц мэдээллүүдийг авч чадсан өндөр ач холбогдолтой сургалт семинар болсон гэж үзэж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТЗСАМЭРГЭЖИЛТЭН

Ж.ЭНХБОЛД